



Биологийн олон янз
байдлын конвенц

ДЭЛХИЙ ЭЭЖЭЭ ХАЙРЛАЦГААЯ, ХАМГААЛЦГААЯ



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 2015-2025



- 4 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
- 14 ЗОРИЛГО
- 29 ЗОРИЛТ
- 74 ХҮРЭХ ҮР ДҮН






БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Биологийн олон янз байдлын хөтөлбөрийн зорилго, зорилтуудын эмхтгэлийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга төслийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

Хөтөлбөрийн дэлгэрэнгүй хувилбар: <http://www.legalinfo.mn/annex/details/6909?lawid=11359>
<https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-mn.pdf>



Биологийн олон янзын байдал гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янзын байдал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.

Биологийн олон янз байдлын тухай конвенцийг Монгол Улсын Их Хурал 1993 онд соёрхон баталснаар Монгол Улс тус конвенцид албан ёсоор нэгдэн орсон дэлхийн 30 дахь орон болсон юм. Конвенцид манай улс нэгдэн орсноор биологийн олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, генетик нөөцийн ашиглалтаас олох ашгийг шударга, тэгш, хүртээмжтэй хуваарилах үндсэн гурван зорилгод чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, олон улс, бүс нутгийн хэмжээнд санаачилгатай хамтран ажиллах, үндэсний

бодлого, үр ашигтай зохицуулалтыг хэрэгжүүлэх үүргийг олон улсын өмнө хүлээсэн.

Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын Бага Хурлын 10 дугаар хуралдаанаас “Айчи-20 зорилт”-ыг боловсруулан баталж, конвенцид нэгдсэн орон бүрийг өөрийн улсын биологийн олон янз байдлын хөтөлбөрийг тус зорилтод нийцүүлэн боловсруулах зөвлөмжийг гаргасан.

Монгол орны биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцлийг бүрдүүлэх явдал мөн.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 325 дугаар тогтоолоор баталсан болно. Хөтөлбөрийн зорилт бүрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг биологийн олон янз байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төлөвлөн холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

АЙЧИ-20 ЗОРИЛТ



Энэхүү үндэсний хөтөлбөр нь Монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглалтыг 2025 он хүртэл хангах **4** тэргүүлэх чиглэлийн хүрээнд **14** зорилго, **29** зорилт, **74** хүрэх үр дүнгээс бүрдэнэ.



1 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх

2 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх

3 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах

4 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах

1 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх



ЗОРИЛГО 1:

Бүх шатны боловсролын түвшний агуулгад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгаж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 5-аас доошгүй хувь нь энэ талаар мэдээлэл түгээдэг болох

Зорилт 1: Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч болон олон нийтийн хамтын ажиллагааг уялдуулах, сайжруулах

Зорилт 2: Иргэдэд тогтвортой хөгжлийн үзэл санааг системтэй, цогц байдлаар олгох




ЗОРИЛГО 2:

Байгаль орчны мэдээллийн сангийн биологийн олон янз байдлын мэдээллийн нэр төрөл, хүртэцийг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад ашиглах тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 3: Биологийн олон янз байдлын талаарх судалгааны ажлыг дэмжих төр, хувийн хэвшлийн тогтолцоо, эдийн засгийн хөшүүргийг бий болгох

Зорилт 4: Биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, зохистой ашиглах талаарх мэдээллийг шийдвэр гаргагч болон олон нийтэд ойлгомжтой, системтэйгээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх



2 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх



ЗОРИЛГО 3:

Эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүдийн генетикийн нөөцийг хамгаалах, ашиглах, түүний үр өгөөжөөс шударга хүртэх эрх зүйн орчинг бүрдүүлж зохистой ашиглах, генетикийн доройтол, хомсдолоос сэргийлэх

Зорилт 5: Монгол Улсын нутаг дэвсгэр дэх малын үүлдэр, омог, унаган болон таримал ургамлын сорт, тэдгээрийн зэрлэг овог, төрөл, зүйлийг бүртгэлжүүлэх, төлөв байдлын үнэлгээ хийх, хомсдолоос хамгаалах

Зорилт 6: Генийн эргэлтийн нөөц болон хувиргасан амьд организмыг бүртгэлжүүлэх, генетик нөөцийн сан бүрдүүлэх

Зорилт 7: Генетикийн нөөцийг ашиглах, үр өгөөжийг шударга хүртээх тухай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх



ЗОРИЛГО 4:

Унаган, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх

Зорилт 8: Монгол орны унаган, нэн ховор, ховор зүйлийг цогцоор хамгаалах, ашиглах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

Зорилт 9: Монгол оронд тархаж байгаа харь зүйл амьтан, ургамлыг судлах, түрэмгийлэгч харь зүйлийг тархан суурьшихаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх



ЗОРИЛГО 5:

Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах

Зорилт 10: Газар зохион байгуулалтын улсын болон орон нутгийн төлөвлөгөөнд экосистемийн төлөөлөлд суурилсан тусгай хамгаалалттай газар нутгийг тусган сүлжээг өргөтгөж бэхжүүлэх

Зорилт 11: Талуудын оролцоонд тулгуурласан тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, чадавхийг сайжруулах

Зорилт 12: Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг тодорхойлж, хамгаалах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх



ЗОРИЛГО 6:

Хөрс, усыг химийн болон шим бодисын бохирдлоос хамгаалах

Зорилт 13: Хотжилт, уул уурхай, үйлдвэржилтээс үүдэлтэй химийн бодисын бохирдолтой холбоотой хуулийн хэрэгжилтийн хяналтад төр, олон нийтийн хамтын оролцоог хангах

Зорилт 14: Хөдөө аж ахуйд ашигладаг химийн бодисын зохистой хэрэглээ, түүний хяналт, биологийн олон янз байдалд үзүүлэх шууд болон дам нөлөөний талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх

Зорилт 15: Ургамал хамгаалах болон ургац нэмэгдүүлэх бодисын зохистой хэрэглээний хяналтын механизм бүрдүүлэх





ЗОРИЛГО 7:

Ойн менежментийг сайжруулсанаар 2025 онд монгол орны ой ойрхог чанарыг 9 хувьд хүргэж, түүний доторх биологийн олон янз байдлыг хамгаалах

Зорилт 16: Төрөөс ойн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах

3 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдлын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах



ЗОРИЛГО 8:

Төр, нутгийн иргэд, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар байгалийн нөөц, ялангуяа агнуурын амьтны нөөцийн зохистой ашиглах, хамгааллын менежментийг нэвтрүүлэх

Зорилт 17: Нутгийн иргэдийн нөхөрлөл бэлчээр, ан амьтан, ургамал, ой, ойн дагалдах баялаг зэрэг хүрээлэн байгаа байгалийн нөөцөө цогцоор хариуцах эрх зүйн орчин бий болгох

Зорилт 18: Агнуурын бүс нутагт ан агнуурын менежментийг хэрэгжүүлэх



ЗОРИЛГО 9:

Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай үялдуулсан хууль эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг бий болгон монгол орны бэлчээрийн доройтлыг 70 хүртэл хувиар бууруулж сайжруулах

Зорилт 19: Газрын тухай багц хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичигт экосистемийн тэнцвэрт байдлыг бүрэн хамгаалсан мал аж ахуй эрхлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох

Зорилт 20: Үржил шимийн доройтолд орсон хөрсийг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг хөрсийг хамгаалах, доройтолд орохоос урьдчилан сэргийлэх санхүүгийн тогтвортой тогтолцоог бий болгох



ЗОРИЛГО 10:

Тариалангийн үйлдвэрлэлийн техник технологи, үйл ажиллагааг орчныхоо агробиоценоз дахь биологийн төрөл, зүйлүүдийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангахад нийцүүлэн шинэчлэх

Зорилт 21: Хөдөө аж ахуйн салбарын газар ашиглалтыг биологийн олон янз байдлыг хамгаалах бодлоготой уялдуулах

4 | ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах



ЗОРИЛГО 11:

Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд тусган хэрэгжүүлэх

Зорилт 22: Цогц судалгаанд үндэслэсэн биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж үндэсний тооцооны системд нэвтрүүлэх

Зорилт 23: Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах асуудлыг холбогдох салбаруудын бодлого, хөтөлбөртэй уялдуулах



ЗОРИЛГО 12:

Байгаль орчны стратегийн үнэлгээнд үндэслэн хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл ажиллагаанд төсвөөс татаас болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 24: Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа эдийн засгийн хөшүүргийг бууруулах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх

Зорилт 25: Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглахыг дэмжих эдийн засгийн механизмыг боловсруулж хэрэгжүүлэх



ЗОРИЛГО 13:

Бэлчээр, усны нөөц, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг тооцож нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх

Зорилт 26: Экосистемийн үйлчилгээг үнэлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох

Зорилт 27: Экосистемийн үйлчилгээний төлбөр (цаашид "ЭҮТ" гэх)-ийг нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх



ЗОРИЛГО 14:

Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн боломжит гол эх үүсвэрийг тодорхойлж, үр нөлөөтэй ашиглах тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 28: Биологийн олон янз байдалд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Засгийн газрын бүх тусгай санд байгаль орчинд ээлтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгах

Зорилт 29: Биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн орлогын эх үүсвэр (тухайлбал: экологийн үйлчилгээний төлбөр, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал)-ийг тодорхойлж нэвтрүүлэх.

